

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга 0

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-6

1.Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх, хэлэлцүүлэх/ 3-6

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
12 дугаар сарын 26-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 68.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 11 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: О.Амгаланбаатар, Ч.Анар, Э.Бат-Амгалан, Б.Батбаатар, Б.Дэлгэрсайхан, Х.Жангабыл, Б.Энхбаяр, Д.Энхтүвшин.

Нэг.Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх, хэлэлцүүлэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Санхүүгийн бодлогын газрын Олон улсын санхүүгийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга Г.Болормаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хуулийн төслийн талаарх танилцуулгыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр үг хэлэв.

Г.Тэмүүлэн: Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 10
Бүгд: 17
41.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 8
Бүгд: 17
52.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Тэмүүлэн: Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 11 минут үргэлжилж, 25 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 68.0 хувийн ирцтэйгээр 13 цаг 22 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
13 цаг 11 минут.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Г.Тэмүүлэн: Гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаан эхлэхэд бэлэн болсон байна. Ирцийг та бүхэнд танилцуулъя.

Наранцэцэгийн Алтаншагай гишүүн, Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн, Энхбатын Болормаа гишүүн, Дашдондогийн Ганбат гишүүн, Батбаярын Жаргалан гишүүн, Нанзадын Наранбаатар гишүүн, Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн, Нянтайширын Номтойбаяр гишүүн, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн, Ганбатын Хосбаяр гишүүн, Дамдины Цогтбаатар гишүүн, Өлзийхүүгийн Шижир гишүүн, Жадамбын Энхбаяр гишүүн, Лутаагийн Энхнасан гишүүн, Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн, Равжихын Эрдэнэбүрэн гишүүд хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны хуралдааны ирц бүрдсэн байна.

Ингээд 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх нэг асуудал байгаа.

Хэлэлцэх асуудлыг танилцуулъя Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах тухай хуулийн төсөл байгаа. Засгийн газар 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн соёрхон батлах асуудал байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа орцгооё. Хэлэлцэх асуудалтай холбоотой гишүүд байхгүй байсан.

Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Лувсандоржийн Сонор, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Олон улсын санхүүгийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга Ганболдын Болормаа, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Булганхүүгийн Ганзориг гэсэн бүрэлдэхүүнтэй байна. Жавхлан сайд ирж оролцох ёстой. Сайдыгаа дуудаарай.

Ингээд Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Энхбаяр сайд танилцуулна. Энхбаяр сайдын микрофоныг өгье.

Ж.Энхбаяр: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ та бүгдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Монгол Улс нь 2000 оны 7 дугаар сарын 26-ны өдөр Европын сэргээн босголт, хөгжлийн банкныг үүсгэн байгуулах тухай хэлэлцээрийг хүлээн зөвшөөрч, Монгол Улсын Их Хурал соёрхон баталснаар тус банкны 61 дэх гишүүнээр элсэн орсон билээ.

Европын сэргээн босголт, хөгжлийн банкны Захирагч нарын зөвлөл 2023 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 259 болон 260 дугаар тогтоолыг баталж Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрийн 1 дүгээр зүйл болон 12.1 дүгээр зүйлүүдэд өөрчлөлт оруулахаар шийдвэр хэлсэн байна.

Тус хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд оруулсан өөрчлөлтөөр Европын сэргээн босголт, хөгжлийн банкны санхүүжилтийн үйл ажиллагаа нь Төв болон Зүүн Европ, Өмнөд болон Зүүн газар дундын тэнгисийн бүс нутаг болон Монгол зэрэг орнуудыг хамарч байсныг өргөжүүлж Сахарын цөлөөс өмнөд Африкийн бүс нутгийн орнуудад үйл ажиллагаагаа явуулах боломж бүрдэж байгаа бол хэлэлцээрийн 12.1 дүгээр зүйлд оруулсан өөрчлөлт нь тус банкны санхүүгийн тогтвортой байдлыг хамгаалахын тулд Европын сэргээн босголт, хөгжлийн банкны Захирлуудын зөвлөлд хөрөнгийн зохистой харьцааны хэмжүүрүүдтэй холбоотой тохирох хязгаарлалтыг тогтоон хадгалах эрхийг олгож байгаа болно.

Энэхүү хэлэлцээрт оруулсан өөрчлөлтүүд нь Европын сэргээн босголт, хөгжлийн банкны дотоод засаглал, үйл ажиллагааны хүрээнд тус банкны үйл ажиллагааг төрөлжүүлж банкны тогтвортой байдал болон гишүүн орнуудад үзүүлэх дэмжлэгийг сайжруулахад чиглэгдэж байна.

Өмнө нь 2013 онд тус банкнаас Өмнөд болон Зүүн газар дундын тэнгисийн бүс нутагт үйл ажиллагаагаа тэлэх зорилгоор Европын сэргээн босголт, хөгжлийн банкныг үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг манай улс мөн хүлээн зөвшөөрч соёрхон баталж байсан болно.

Тус хэлэлцээрт оруулсан өөрчлөлтийг 2025 оны 1 дүгээр сараас мөрдөж эхлэх бөгөөд Европын сэргээн босголт, хөгжлийн банкны гишүүн орнуудын дөрөвний гурваас доошгүй хувь нь хүлээн зөвшөөрсөн тохиолдолд хүчин төгөлдөр болно.

Иймд хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Энхбаяр сайдад баярлалаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу?

Алга байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулж үг хэлэх гишүүд байна уу?

Алга байна.

Санал хураалтыг явуулна. Гишүүдийг дуудаарай.

Тэгье. Энхбаяр сайдад микрофон өгье. Үг хэлнэ.

Ж.Энхбаяр: Энэ Монгол Улсын Засгийн газар Европын сэргээн босголт, хөгжлийн банктэй хамтран хэрэгжүүлж байгаа хэд хэдэн томоохон төслүүд байдаг. Монгол Улсад одоо байнга тусалж, дэмжиж ирсэн. Энэ дээр товч мэдээлэл өгье.

Улаанбаатар-Дарханы 2 эгнээ зам барих энэ нэмэлт төсөл санхүүжилтийг 157 сая ам.доллараар санхүүжүүлж амжилттай хэрэгжиж байгаа.

Чойр-Сайншандын цахилгаан дамжуулах агаарын шугамын дэд станцын барих төслийг 62.8 сая доллароор тусалж, энэ хүрээнд 12.7 сая доллар нь буцалтгүй тусламжаар хэрэгжиж явж байгаа.

Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн төсөл дээр 10 сая долларын зээл олгогдсон. Мөн 5 сая доллар нь буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа. Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй байдлын төслийг 7 сая доллароор санхүүжүүлж, 6.2 сая доллар нь буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа.

Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэг барих төсөл 43.2 сая доллароор санхүүжүүлж 8 сая долларын тусламжаар хэрэгжиж байгаа. Улаанбаатар хотын ногоон орон сууц барих төслийг 20 сая доллароор дэмжиж, 5 сая доллар нь тусламжийн хүрээнд хэрэгжиж байгаа. Энэ мэтчилэн ийм төслүүдийг Европын сэргээн босголт, хөгжлийн банктэй Монгол Улсын Засгийн газар хэрэгжүүлж байгаа байгаа мэдээлэл байна.

Г.Тэмүүлэн: Санал хураалтыг явуулна. Санал хураалт явуулахаас өмнө бүртгэлийн санал хураалтыг явуулъя. Тест, эхний бүртгэлийн санал хураалт.

Одоо албан ёсоор санал хураалтыг явуулъя.

Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт.

Горимын санал гаргая Эрдэнэболд гишүүн.

С.Эрдэнэболд: Би төхөөрөмжтэйгөө буруу харьцаад татгалзсан санал руу орчихлоо. Дахиад горимын саналаар санал хураахыг хүсэж байна.

Г.Тэмүүлэн: Эрдэнэболд гишүүний гаргасан горимын саналыг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя. Өмнөх санал хураалтыг хүчингүй болгоё. Санал хураалт.

Эрдэнэболд гишүүний горимын санал дэмжигдлээ. 52.9 хувиар дэмжигдлээ.

Ингээд горимын санал дэмжигдсэн учраас санал хураалтыг дахин явуулъя.

Ингээд Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Гишүүд анхаар.

58.8 хувиар дэмжигдлээ.

Байнгын хорооны гишүүддээ баярлалаа.

Ингээд санал хураалт явуулж дууслаа.

Санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд бэлдэх ёстой байгаад байгаа. Энхбаяр, маргааш та яах уу? Тэгийг Хосбаяр гишүүн илтгэнэ.

Өнөөдрийн хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрснийг мэдэгдье.

Гишүүддээ баярлалаа. Ажлын хэсэгт баярлалаа.

13.22 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР